



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/867

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 онд зохион байгуулагдсан багш нарын баяраар ахмад багш нарын гарын бэлэгний зардалд 571 900 төгрөг, Баруун бүсийн зөвлөлийн уулзалтын зардалд 415 200 төгрөг, НАМЭХ-ний чуулганы зардлын дэмжлэгт 782 000 төгрөг, Гавьяат малчин Л.Баттулгад хүндэтгэл үзүүлэхэд 474 000 төгрөг, Ахмадын баярын бэлэгний уутны зардалд 715 000 төгрөг, бэлэг дурсгалын зардалд 865 500 төгрөг, Бүсийн оношлогоо эмчилгээний төвд ирж ажилласан Солонгос улсын эмч нартай хийсэн уулзалтын зардалд 504 00 төгрөг, Сум багийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын чуулганы арга хэмжээний зардлын дэмжлэгт 418 300 төгрөг, Жаазтай өргөмжлөл, батламж захиалан хийлгэсэн зардалд 620 000 төгрөг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 5 365 000 төгрөг /Таван сая гурван зуун жаран таван мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



02 D/Zax-A/867-Da